

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/205/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ХҮМҮҮН ЦЭЦЭРЛЭГИЙН 2021
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Төлбөрийн акт	19
4.3 Албан шаардлага.....	19
4.4 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, Иймэл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/95
танай -ны № -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020324

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>73,964,757.56</u>	<u>71,315,350.19</u>
33	АВЛАГА	383,240.37	344,629.00
335	Бусад авлага	383,240.37	344,629.00
3351	Байгууллагаас авах авлага	383,240.37	344,629.00
35	БАРАА МАТЕРИАЛ	73,581,517.19	70,970,721.19
351	Түүхий эд материал	722,520.00	680,720.00
35130	Эм боох материал	722,520.00	680,720.00
354	Хангамжийн материал	72,858,997.19	70,290,001.19
35410	Бичиг хэргийн материал	27,700.00	298,900.00
35420	Аж ахуйн материал	65,183,074.19	68,034,224.19
35440	Түлш, шатах тослох материал	00.00	80,000.00
35450	Барилгын засварын материал	57,000.00	54,000.00
35460	Хүнсний материал	5,459,573.00	604,527.00
35470	Бусад хангамжийн материал	2,131,650.00	1,218,350.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,504,008,111.93</u>	<u>1,459,502,088.67</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,504,008,111.93	1,459,502,088.67
392	Биет хөрөнгө	1,422,308,111.93	1,377,802,088.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,452,292,949.32	1,452,292,949.32
39202	Хуримтлагдсан элэгдэл	-103,298,555.52	-136,335,660.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	50,149,731.75	44,968,052.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-20,388,380.91	-23,008,832.08
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,559,829.38	37,193,976.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,832,573.38	-16,805,303.19
39214	Бусад үндсэн хөрөнгө	29,037,634.00	30,522,409.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,212,522.71	-11,025,502.96
393	Биет бус хөрөнгө	81,700,000.00	81,700,000.00
39301	Программ хангамж	730,000.00	440,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-730,000.00	-440,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	81,700,000.00	81,700,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,577,972,869.49</u>	<u>1,530,817,438.86</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>240,871.17</u>	<u>52,104.54</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	240,871.17	52,104.54
413	Өглөг	240,871.17	52,104.54
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	52,104.54
4136	Бусад өглөг	240,871.17	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	225,321.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	15,550.17	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,577,731,998.32</u>	<u>1,530,765,334.32</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,577,731,998.32	1,530,765,334.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	81,700,000.00	81,700,000.00

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51101	Өмч: - төрийн	81,700,000.00	81,700,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,332,572,338.10	1,285,605,674.10
51210	Өмнөх үеийн үр дүн	1,332,572,338.10	1,332,572,338.10
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-46,966,664.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	163,459,660.22	163,459,660.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,577,972,869.49</u>	<u>1,530,817,438.86</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	748,545,400.00	652,866,367.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,889,800.00	534,728,767.20
120	Нийтлэг татварын бус орлого	8,848,800.00	5,688,720.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,848,800.00	5,688,720.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,848,800.00	5,688,720.00
122	Тусламжийн орлого	1,041,000.00	466,147.20
122001	Хандив тусламж /дотоод/	1,041,000.00	466,147.20
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	528,573,900.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	528,573,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	164,339,800.00	118,137,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	574,315,800.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	59,015,700.00	12,813,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,015,700.00	12,813,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	105,324,100.00	105,324,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	105,324,100.00	105,324,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	790,356,934.04	699,833,031.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	790,356,934.04	699,833,031.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	608,674,136.40	594,738,340.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	376,808,681.94	383,956,648.95
210101	Үндсэн цалин	376,589,779.94	287,577,114.70
210102	Нэмэгдэл	218,902.00	60,741,501.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	8,772,000.00
210104	Урамшуулал	00.00	26,866,033.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,185,022.42	49,568,444.06
210201	Тэтгэврийн даатгал	32,974,034.40	35,177,747.03
210202	Тэтгэмжийн даатгал	3,879,297.40	3,910,967.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,019,437.52	3,085,093.13
210204	Ажилгүйдлийн даатгал	654,250.06	666,801.88
210205	Эрүүл мэндийн даатгал	6,658,003.04	6,727,834.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,770,821.60	89,269,974.20
210301	Гэрэл, цахилгаан	4,704,414.00	3,349,533.00
210302	Түлш, халаалт	81,264,545.80	81,263,547.80
210303	Цэвэр, бохир ус	4,801,861.80	4,656,893.40
2104	Хангамж, бараа материалын зардал	14,588,486.92	4,412,109.90
210401	Бичиг хэрэг	3,714,810.00	717,350.00
210402	Тээвэр, шатахуун	150,000.00	70,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,005,738.00	1,047,910.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	540,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,686,800.00	1,976,849.90

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210408	Бараа материал акталсны зардал	5,491,138.92	00.00
2105	Нормативт зардал	31,880,066.00	11,376,233.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,750.00	101,100.00
210502	Хоол, хүнс	31,768,216.00	10,253,923.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	61,100.00	1,021,210.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	119,790.00	500,410.00
210604	Урсгал засвар	119,790.00	500,410.00
2107	Томилолт, зочны зардал	64,000.00	32,000.00
210702	Дотоод албан томилолт	64,000.00	32,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	963,800.00	1,136,580.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	963,800.00	1,136,580.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,293,467.52	54,485,940.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,899,990.00	2,436,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,697,670.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,393,477.52	50,352,170.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	181,682,797.64	105,094,690.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,815,700.00	12,113,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	45,865,600.00	5,064,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	12,950,100.00	7,048,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	92,981,190.53
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	92,981,190.53
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	122,867,097.64	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	122,867,097.64	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-41,811,534.04	-46,966,664.00
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,899,990.00	00.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	1,899,990.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	1,899,990.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-39,911,544.04	-46,966,664.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	81,700,000.00	135,404,544.22	1,373,242,774.09	1,590,347,318.31
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	81,700,000.00	135,404,544.22	1,373,242,774.09	1,590,347,318.31
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	7,901,950.04	7,901,950.04
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	81,700,000.00	163,459,660.22	1,332,572,338.10	1,577,731,998.32
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	81,700,000.00	163,459,660.22	1,332,572,338.10	1,577,731,998.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	81,700,000.00	163,459,660.22	1,332,572,338.10	1,577,731,998.32
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-46,966,664.00	-46,966,664.00
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	81,700,000.00	163,459,660.22	1,285,605,674.10	1,530,765,334.32

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	738,655,600.00	646,711,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	528,573,900.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	528,573,900.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	528,573,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	738,655,600.00	118,137,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	574,315,800.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	59,015,700.00	12,813,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,015,700.00	12,813,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	105,324,100.00	105,324,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	105,324,100.00	105,324,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	738,655,600.00	644,931,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	738,655,600.00	644,931,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	556,972,802.36	539,736,809.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	376,879,045.43	383,933,586.52
210101	Үндсэн цалин	240,635,287.99	248,519,324.15
210102	Нэмэгдэл	89,266,489.22	84,800,759.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,522,008.49	14,128,000.00
210104	Урамшуулал	33,455,259.73	36,485,502.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,140,440.13	49,516,340.75
210201	Тэтгэврийн даатгал	35,224,154.03	35,158,140.47
210202	Тэтгэмжийн даатгал	3,189,666.62	3,902,842.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,413,115.63	3,078,593.59
210204	Ажилгүйдлийн даатгал	569,042.97	665,176.07
210205	Эрүүл мэндийн даатгал	5,744,460.88	6,711,588.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,001,879.80	89,269,974.20
210301	Гэрэл, цахилгаан	4,704,414.00	3,349,533.00
210302	Түлш, халаалт	81,264,545.80	81,263,547.80
210303	Цэвэр, бохир ус	5,032,920.00	4,656,893.40
2104	Хангамж, бараа материалын зардал	3,119,997.00	3,228,890.00
210401	Бичиг хэрэг	200,000.00	200,000.00
210402	Тээвэр, шатахуун	150,000.00	150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	280,000.00
210404	Ном, хэвлэл	120,000.00	120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,449,997.00	1,978,890.00
2105	Нормативт зардал	34,586,750.00	8,348,308.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,750.00	100,800.00
210502	Хоол, хүнс	33,636,000.00	5,398,877.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	850,000.00	2,848,631.00

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	64,000.00	32,000.00
210702	Дотоод албан томилолт	64,000.00	32,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	760,000.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	760,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,920,690.00	4,907,710.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,156,600.00	3,109,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,764,090.00	1,797,910.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	181,682,797.64	105,194,690.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,815,700.00	12,213,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	45,865,600.00	5,064,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	12,950,100.00	7,048,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	92,981,190.53
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	92,981,190.53
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	122,867,097.64	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	122,867,097.64	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	1,780,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	1,780,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	1,780,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	1,780,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	1,780,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-1,780,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	633,898,000.00	540,916,809.47	92,981,190.53	85.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	633,898,000.00	540,916,809.47	92,981,190.53	85.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	633,898,000.00	540,916,809.47	92,981,190.53	85.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	408,505,000.00	383,933,586.52	24,571,413.48	93.99
210101	Үндсэн цалин	261,715,500.00	248,519,324.15	13,196,175.85	94.96
210102	Нэмэгдэл	89,511,900.00	84,800,759.70	4,711,140.30	94.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,960,000.00	14,128,000.00	832,000.00	94.44
210104	Урамшуулал	42,317,600.00	36,485,502.67	5,832,097.33	86.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,148,100.00	49,516,340.75	5,631,759.25	89.79
210201	Тэтгэврийн даатгал	38,807,700.00	35,158,140.47	3,649,559.53	90.60
210202	Тэтгэмжийн даатгал	4,084,600.00	3,902,842.27	181,757.73	95.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,267,800.00	3,078,593.59	189,206.41	94.21
210204	Ажилгүйдлийн даатгал	816,500.00	665,176.07	151,323.93	81.47
210205	Эрүүл мэндийн даатгал	8,171,500.00	6,711,588.35	1,459,911.65	82.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	104,824,100.00	89,269,974.20	15,554,125.80	85.16
210301	Гэрэл, цахилгаан	10,520,000.00	3,349,533.00	7,170,467.00	31.84
210302	Түлш, халаалт	81,269,200.00	81,263,547.80	5,652.20	99.99
210303	Цэвэр, бохир ус	13,034,900.00	4,656,893.40	8,378,006.60	35.73
2104	Хангамж, бараа материалын зардал	4,470,000.00	4,468,890.00	1,110.00	99.98
210401	Бичиг хэрэг	200,000.00	200,000.00	00.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	150,000.00	150,000.00	00.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	280,000.00	280,000.00	00.00	100.00
210404	Ном, хэвлэл	120,000.00	120,000.00	00.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	500,000.00	00.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,220,000.00	3,218,890.00	1,110.00	99.97
2105	Нормативт зардал	55,500,800.00	8,348,308.00	47,152,492.00	15.04
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,800.00	100,800.00	00.00	100.00
210502	Хоол, хүнс	52,550,000.00	5,398,877.00	47,151,123.00	10.27
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,850,000.00	2,848,631.00	1,369.00	99.95
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00	00.00	100.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	00.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	100,000.00	32,000.00	68,000.00	32.00
210702	Дотоод албан томилолт	100,000.00	32,000.00	68,000.00	32.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4850000.00	4847710.00	2,290.00	99.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,050,000.00	3,049,800.00	200.00	99.99

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,800,000.00	1,797,910.00	2,090.00	99.88
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	633,898,000.00	620,075,779.80	13,822,220.20	97.82
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	528,573,900.00	528,573,900.00	00.00	100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	528,573,900.00	528,573,900.00	00.00	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	105,324,100.00	91,501,879.80	13,822,220.20	86.88
132001	Орон нутгийн төсвөөс	105,324,100.00	91,501,879.80	13,822,220.20	86.88
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	34.00	34.00	00.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	00.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	17.00	17.00	00.00	100.00

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,813,500.00	12,813,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,813,500.00	12,813,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	600,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	600,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	600,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,213,500.00	12,213,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,213,500.00	12,213,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,064,900.00	5,064,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,048,600.00	7,048,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	100,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,813,500.00	12,813,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,813,500.00	12,813,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,813,500.00	12,813,500.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор С.Батжаргал, Э.Батчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цэцэрлэг нь орон нутгийн болон бага насны хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээг тусгасан сургалтын хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэн, хүүхэд нэг бүрийг бүтээлээр хөгжих, төлөвших боломжийг бий болгохыг эрхэм зорилгоо болгон анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөвт зардал 633,898.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,508.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,131.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 633,898.0 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 12,813.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 644,931.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 432.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,634.1 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,780.0 мянган төгрөгийн бусад хөрөнгө, нийт 5,846.1 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,780.0 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 3,600.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 2,088.7 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 19,411.6 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 24,327.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 344.6 мянган төгрөгийн авлага, 52.1 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа

материал 70,970.7 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 1,459,502.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-		-
Авлага	383.24	344.63	(38.61)
Урьдчилгаа			-
Бараа материал	73,581.52	70,970.72	(2,610.80)
Үндсэн хөрөнгө	1,504,008.11	1,459,502.09	(44,506.02)
Нийт хөрөнгө	1,577,972.87	1,530,817.44	(47,155.43)
Өр төлбөр	240.87	52.10	(188.77)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,577,732.00	1,530,765.33	(46,966.66)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,577,972.87	1,530,817.44	(47,155.43)

Бараа материалын дансны үлдэгдэл 70,970.7 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 2,610.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,459,502.1 мянган төгрөг болж 44,506.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,530,765.3 мянган төгрөг болж 46,966.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 633,898.0 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 633,898.0 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 633,898.0 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 633,898.0 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 540,916.8 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 92,981.2 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 540,916.8 мянган төгрөг буюу 85.3 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 12,813.5 мянган төгрөг төвлөрч, бараа үйлчилгээний бусад зардалд 600.0 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 5,064.9 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн зардалд 7,048.6 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 100.0 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 432.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,634.1 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,780.0 мянган төгрөгийн бусад хөрөнгө, нийт 5,846.1 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,780.0 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 3,600.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 10 нэр төрлийн 4,920.2 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 1,300.0 мянган төгрөгийн үнэ бүхий ажлын хувцас бэлтгэсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 134 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,944.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгөгдсөнийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 1 алдаа зөрчил нь тайлант онд давтан гарч байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,660.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6,220.2 мянган төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага, 440.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулах алдаа зөрчил илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.3 Албан шаардлага

Аудитаар 6,220.2 мянган төгрөгийн зөрчил арилгах 2 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 10 нэр төрлийн 4,920.2 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 тоот тогтоол, УСНББОУС 12-той тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн хөрөнгө материалыг үнэн зөв бүртгэж байх, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант оны 12 дугаар сард төсвийн хөрөнгөөр 1,300.0 мянган төгрөгийн үнэ бүхий ажлын хувцас бэлтгэсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.4-д "Энэ тогтоол батлагдсанаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн батлагдсан төсвийн үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, холбогдох дээд шатны байгууллагын гаргасан тушаал шийдвэрийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 1 нэр төрлийн 440.0 мянган төгрөгийн үнэ бүхий биет бус хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай

зөвшилцөн тогтоох" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглагдах боломжгүй хөрөнгийг холбогдох дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх

2. *Шилэн данстай холбоотой асуудал*

2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 134 мэдээллийг хугацаандаа, 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээллэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон "Дундманхайдай Аудит" ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д / Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цэцэрлэг	4	6,660.2	-	-	-	-	2	6,220.2	2	440.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn